



## 2021 ОНД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалыг тус тус мөрдлөг болгон салбарын хэмжээнд цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан, хуулийн хугацаанд нь хариуг өгч ажиллалаа.

Нэг. Батлан хамгаалах салбарын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар иргэдээс 10168 өргөдөл, гомдол ирүүлснээс 9386 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилт 92,3 хувьтай байна. Өнөөдрийн байдлаар харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд 652 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шилжүүлсэн байгаа бөгөөд шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа 130 өргөдөл (хугацаа болоогүй) байна.



Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нийт 5 сувгаар (иргэдийг хүлээн авах байранд биечлэн; 458929 дугаарын утсаар; Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн; “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар; шуудангаар; яамны цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар) хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан болно.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоог хүлээн авсан сувгуудаар нь ангилбал:

- 9622 буюу 94,7 хувь нь бичгээр;
- 267 буюу 2,6 хувь нь “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар;
- 17 буюу 0,16 хувь нь цахимаар;
- 17 буюу 0,16 хувь нь ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс;
- 245 буюу 2,4 хувь нь биечлэн уулзсан тус тус ирүүлжээ.

Өргөдлийг агуулгаар нь ангилбал:

- |   |                      |
|---|----------------------|
| 1. Нийгмийн хамгааллын асуудлаар                    | 2519 буюу 24,7 хувь; |
| 2. Ажлын байртай холбоотой асуудлаар                | 2876 буюу 28,2 хувь; |
| 3. Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах     | 1059 буюу 10,4 хувь; |
| 4. ЭДА-ны сонгон шалгаруулалттай холбоотой          | 1001 буюу 9,8 хувь;  |
| 5. Ахмад дайчинтай холбоотой асуудлаар              | 43 буюу 0,4 хувь;    |
| 6. Бусад 2670 буюу 26,2 хувийг тус тус эзэлж байна. |                      |

Ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дийлэнх буюу 62,8 хувийг цэргийн алба хаагчид бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагч, ажилтан алба хаагчдаас ирүүлсэн ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах болон нийгмийн хамгааллын асуудал, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхийг хүссэн өргөдөл эзэлж байгаа юм.


Нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдлийг судлан үзэхэд тодорхой хугацаа шаардсан, тухай бүрт нь шийдвэрлэхэд хүндрэлтэй (албан тушаалын орон сууц олгуулах, мөнгөн дэмжлэг хүссэн г.м) өргөдлүүд байгаа бөгөөд коронавируст цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2023 он хүртэл шинээр орон сууц барих төсөв батлагдаагүй тухай тайлбарлаж, хариуг хүргүүлсэн байна.

Хоёр. Батлан хамгаалах яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах яамны удирдлагад хандаж иргэдээс 381 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 366 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 15 өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн өгсөн ба хэрэгжилт 96.0 хувьтай байна. 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар (Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох, сунгах) 10 өргөдлийг 2022 онд Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг албан тушаалтнуудад хандаж гаргаснаар нь харуулбал:

- |  |                     |
|--|---------------------|
| - Батлан хамгаалахын сайдад                                | 141 буюу 37,0 хувь; |
| - Батлан хамгаалахын дэд сайдад                            | 7 буюу 1,8 хувь;    |
| - Төрийн нарийн бичгийн даргад                             | 177 буюу 46,5 хувь; |
| - Төрийн захиргааны удирдлагын газрын даргад               | 50 буюу 13,1 хувь;  |
| - Бусад газар, хэлтсийн дарга нарт хаяглагдан ирсэн байна. | 6 буюу 1,5 хувь нь  |



Гурав. “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаарт иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар:

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн жинхэнэ алба хаагчидтай холбоотой бүхий л төрлийн санал, хүсэлт, мэдээллийг 24 цаг тасралтгүй хүлээн авч байгаа бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар “Батлан хамгаалах-Иргэний хяналт” 1800-1144 тусгай дугаарт 252 дуудлага ирүүлснийг 100 хувь шийдвэрлэсэн.

Дөрөв. Бусад байгууллагаас харьяаллын дагуу уламжлан ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамны харьяа байгууллагуудаас 2021 онд нийт 22 өргөдөл, гомдол шилжин ирснийг судлан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгч ажиллалаа. Үүнд:

- ҮАБЗ-ийн Нарийн бичгийн даргаас 1 буюу 4,5 хувь;
- Монгол Улсын Их Хурлын даргаас 3 буюу 13,6 хувь;
- Монгол Улсын Их Хурлын гишүүдээс 8 буюу 33,3 хувь;
- Ерөнхийлөгчийн Тамгын газраас 1 буюу 4,5 хувь;
- ЗГХЭГ-аас 1 буюу 4,5 хувь;
- ХЗДХ-ийн сайдаас 1 буюу 4,5 хувь;
- БХЯ-ны харьяа байгууллагаас 7 буюу 31,8 өргөдөл, гомдол шилжин ирсэн.

Тав. Өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх хугацааг багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг богино хугацаанд шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд хариуг нь өгөхөд анхаарал хандуулан ажиллаж байна.

Иргэд, албан тушаалтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг ихэвчлэн албан бичгээр, шаардлагатай тохиолдолд биечлэн амаар, үүрэн холбоогоор аль болох түргэн шуурхай хүргэх хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Зургаа. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн талаар:

2021 оны эхний хагас жилд Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс 2 талархал, 3 хүсэлт, 1 гомдол хуваарилагдан ирсэн байна. Тус төвөөс хуваарилагдаж ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг тухай бүрт нь хүлээн авч тодотгон, холбогдох арга хэмжээг авч, хариуг өгч ажиллаж байна.

Мөн Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, ЗГХЭГ-аас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн улирал, хагас жилээр тайланг гарган, тогтмол хүргүүлэн ажилласан.

Долоо. Байлдаанд оролцсон ахмад дайчид, тэдгээрийн гэр бүлээс ирүүлсэн хүсэлтийг судлан, шийдвэрлэсэн талаар:

2021 оны жилийн эцсийн байдлаар байлдаанд оролцсон ахмад дайчинд тооцуулж, үнэмлэх олгуулах тухай хүсэлт гаргасан 1, ахмад дайчдын ар гэр, үр хүүхдүүдээс орон сууцны дэмжлэг, мөнгөн тусламж хүссэн 8 өргөдөл ирүүлсэн байна.

Дээрх ахмад дайчны үнэмлэх олгуулах, орон сууцны дэмжлэг, мөнгөн тусламж хүссэн өргөдлийг хүлээн авч судлан үзэж, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Байлдаанд оролцсон ахмад дайчдад үнэмлэх, тэтгэмж олгох” журмын 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан “1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд биечлэн оролцсон ахмад дайчид болон дайнд амь үрэгдэгсдийн эхнэр /нөхөр/-т үнэмлэх, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх” гэсний дагуу “Ахмад дайчны үнэмлэх” олгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 170 дугаар зарлигаар тухайн үед амьд сэрүүн байсан Байлдаанд оролцсон үнэмлэхтэй ахмад дайчдад орон сууц, эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох ажлыг зохион байгуулж, 2013 онд дуусгавар болсон байдаг. Уг зарлигт нас барсан ахмад дайчдын үр хүүхдэд орон сууц, эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох тухай заалт тусгагдаагүй тул иргэдэд өргөдөлд дурдсан асуудлыг шийдвэрлэх боломжгүйг тухай бүр албан бичгээр хүргүүлэн ажилласан болно.

Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон гавьяат цолтон, Төрийн шагналт, Төрийн соёрхолт, Ахмад дайчин, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан (1990-1992 он) Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүдэд сар бүр нэмэгдэл олгодог.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар уг нэмэгдлийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас хасч, тухайн ахмад настны шагнагдсан алдар цолны харьяалах салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцад тусган баталсны

дагуу Батлан хамгаалах салбарын харьяаны 93 алдар цолтон, ахмад настнуудад нэмэгдэл мөнгөн дэмжлэгийг хуулийн хүрээнд олгож байна.

Найм. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний зарим алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдлын талаар:

1. Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Зэвсгийн албаны офицер, хошууч Б.Эрдэнэбаярын эмчилгээний зардалд зориулан Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/30 дугаар тушаалаар 5,000,000 (таван сая) төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Тэрээр төдийлөн түгээмэл бус цагаан эсийн хурц хавдар гэсэн оноштойгоор эх орондоо эмчлэгдэх боломжгүй болоод байсан бөгөөд 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр БНТУ-д эмчилгээ хийлгэсэн боловч насан өөд болсон.

2. Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан “Бэлтгэл болон чөлөөнд байгаа Монгол Улсын генерал цолтонд орон сууц, түүний үнийн дүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэх журам”-ыг үндэслэн Монгол төрийн батлан хамгаалах бодлого, цэргийн шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, орчин цагийн Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан чөлөөнд байгаа хошууч генерал Галсансанзайн Махбариад, хошууч генерал Чойжамцын Улаанхүү, чөлөөнд байгаа хошууч генерал Чулууны Цэрэндагва нарт орон сууцны дэмжлэг үзүүлэх зориулалтаар тус бүр 40 сая, нийт 120 сая төгрөгийг олгосон.

3. Батлан хамгаалахын сайдын 2021 оны Б/37 дугаар тушаалаар чөлөөнд байгаа хурандаа Миеэгомбын Батдолгорын эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж 15 сая, мөн Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны Б/240 дугаар тушаалаар чөлөөнд байгаа дэд хурандаа Мөнхөөгийн Өлзийбаярын хагалгааны зардалд зориулж 4,9 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг, мөн Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны Б/259 дүгээр тушаалаар чөлөөнд байгаа ахмад дайчин Сахьяагийн Лувсан-Очир нь зуурдаар нас барсан тул түүний ар гэрт дэмжлэг болгон 200 мянга, нийт 20 гаруй сая төгрөгийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж, Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас тус тус олгосон.

4. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Даваарагчаа нь 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр албан үүргээ гүйцэтгэж яваад цар тахлын халдварт өвчний улмаас таалал төгссөн тул Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэр бүлд нь 247 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үзүүлсэн.

Ес. Дүгнэлт:

Батлан хамгаалах салбарт алба хааж буй цэргийн алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, зохих шийдвэрийг гаргуулан, хуулийн хугацаанд хариуг хурдан шуурхай өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан гэж үзэж байна.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	БХЯ	10168	9386	652	0	130	92,3%

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ  
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	БХЯ	10168	9622	17	267	245	17

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД 2021 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ТӨРЛӨӨР НЬ  
АНГИЛСАН БАЙДАЛ**

<b>/БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ/</b>	<b>Нийт 10168 өргөдлөөс:</b>	
	Хүсэлт	10045 /98,7%/
	Санал	43 /0,42%/
	Гомдол	76 /0,08%/
	Талархал	4 /0,03%/
	Нийгмийн хамгааллын асуудлаар	2519/24,6%/
	Ажлын байртай холбоотой асуудлаар	2876 /28,2%/
	ЭДА-ны сонгон шалгаруулалттай холбоотой	1001 буюу /9,8/
	Сургалттай холбоотой асуудлаар	1059 /10,4%/
	Ахмад дайчинтай холбоотой асуудлаар	43 /0,4%/
	Бусад	2670 /26,2%/
	Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасны дагуу Батлан хамгаалах яамны харьяа 16 байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, түүнийг шийдвэрлэж буй байдлыг шалган, ирүүлсэн тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж илэрсэн зөрчил, дутагдлыг засуулж ажиллалаа.	
	Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нийт 7 сувгаар /иргэдийг хүлээн авах байранд биечлэн; 458929 дугаарын утсаар; Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвөөс хуваарилагдаж ирсэн; “Батлан хамгаалах-Иргэний хяналт”-ын 1800-1144 тусгай дугаараар; шуудангаар; яамны цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр/ хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан болно.	
Тус яаманд иргэд, цэргийн алба хаагчдаас ирсэн өргөдлүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдэж, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан шууд шийдвэрлэх боломжгүй удаан хугацаанд шийдвэрлэгдэх 2140 өргөдлийг тус зааврын 3 дугаар зүйлийн 3.3.7 дахь заалтын дагуу нэр төрөл, агуулга, харилцагчийн шинжээр нь бүлэглэн, тус тусад нь дугаар өгч, бүртгэн хадгалж, шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.		
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дэх хэсэгт заасан “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана” гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр богино хугацаанд шийдвэрлэн иргэнд хариу өгч ажиллаж байна. Үүний үр дүнд Батлан хамгаалах салбарт ирсэн нийт өргөдлийн 36,6 хувийг 1-7 хоногт, 31,6 хувийг 8-14 хоногт, 12,6 хувийг 15-21 хоногт, 11,5 хувийг 22-30 хоногт тус тус шийдэж хариуг өгсөн бөгөөд хуулийн хугацаа хоцроож шийдсэн өргөдөл, гомдол байхгүй байна.		
Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар "Соёмбо" сонин, байгууллагын цахим хаяг, байгууллагын мэдээллийн цагаар бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийж, албан тушаалтнуудад иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу, цаг хугацаанд нь шийдвэрлэж ажиллах талаар тодорхой үүрэг өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.		
Тус яамны харьяа байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан тушаалтан өөрчлөгдөх тохиолдолд бүрт шинээр томилогдсон ажилтанд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль болон журмыг танилцуулан тайлан мэдээ гаргах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.		

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ